



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

БАЯНХОНГОР СУМЫН ЭРДЭНЭМАНДАЛ СУРГУУЛИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АУДИТЫН КОД: БНА-2021/57/СТА-ТШЗ

Баянхонгор 2021 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням Утас: 88089024 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Б.Цэрэнчимэд Утас: 99890393 Цахим хаяг: tserenchimedb@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт /Эх хувь/	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	12
3.Аудитын тайлан	12
3.1. Ерөнхий зүйл	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	13
3.4. Материаллаг байдал	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	15
3.7. Шилэн дансны мэдээлэл	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.9. Аудитын илрүүлэлт	17
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	17
Аудитын зөвлөмж	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	17
4. Менежментийн захидал.....	17
5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	19



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

БАЯНХОНГОР СУМЫН
ЭРДЭНЭМАНДАЛ СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Л.ОНОНХҮҮ ТАНАА

2021.02.25 № 21/46
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын удирдлага аймгийн Боловсрол, соёл урлагийн газар, сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тооцон ажилласан байна.

Тус байгууллага нь ковид-19 цар тахал онцгой дэглэмийн үед аймаг, сумын онцгой комиссоос өгсөн чиглэлийн дагуу ажилласан байна.

2021 А4 ТООТ

005020130

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>223,531,737.66</u>	<u>266,162,304.68</u>
33	АВЛАГА	6,927,808.00	6,301,608.00
335	Бусад авлага	6,927,808.00	6,301,608.00
3351	Байгууллагаас авах авлага	200,000.00	00.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	6,727,808.00	6,301,608.00
35	БАРАА МАТЕРИАЛ	216,603,929.66	259,860,696.68
351	Түүхий эд материал	35,394,326.64	78,712,617.36
35110	Тусгай зориулалттай материал	31,163,826.64	70,118,467.36
35130	Эм боох материал	4,230,500.00	8,594,150.00
354	Хангамжийн материал	181,209,603.02	181,148,079.32
35410	Бичиг хэргийн материал	9,875,190.00	4,394,630.00
35420	Аж ахуйн материал	5,986,880.00	5,845,350.00
35450	Барилгын засварын материал	10,637,662.00	28,237,600.00
35470	Бусад хангамжийн материал	154,709,871.02	142,670,499.32
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,982,944,035.88</u>	<u>4,037,236,035.73</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,982,944,035.88	4,037,236,035.73
392	Биет хөрөнгө	3,347,494,035.88	3,401,786,035.73
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,266,984,656.36	3,383,870,267.36
39202	Хуримтлагдсан элэгдэл	-136,413,116.62	-265,914,696.20
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	230,500,256.62	278,237,708.22
39206	Хуримтлагдсан элэгдэл	-176,915,960.34	-194,566,731.70
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	213,210,834.75	266,178,434.75
39208	Хуримтлагдсан элэгдэл	-119,823,312.89	-140,492,107.70
39217	Ном	69,950,678.00	74,473,161.00
393	Биет бус хөрөнгө	635,450,000.00	635,450,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	640,500,000.00	636,000,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-5,050,000.00	-550,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,206,475,773.54</u>	<u>4,303,398,340.41</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,206,475,773.54</u>	<u>4,303,398,340.41</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,206,475,773.54	4,303,398,340.41
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,468,610,681.55	1,468,610,681.55
51101	Өмч: - төрийн	1,468,610,681.55	1,468,610,681.55
512	Хуримтлагдсан үр дүн	703,095,447.94	800,018,014.81
51210	Өмнөх үеийн үр дүн	703,095,447.94	703,095,447.94
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	96,922,566.87
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,034,769,644.05	2,034,769,644.05
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,206,475,773.54</u>	<u>4,303,398,340.41</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,175,504,900.00	2,452,334,710.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	113,435,720.00	186,100,531.50
120	Нийтлэг татварын бус орлого	113,435,720.00	186,100,531.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	113,435,720.00	186,100,531.50
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	113,235,720.00	186,100,531.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	487,809,880.00	468,047,079.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,574,259,300.00	1,798,187,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,574,259,300.00	1,798,187,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	79,771,980.00	49,264,279.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,544,600.00	43,575,279.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	61,227,380.00	5,689,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	408,037,900.00	418,782,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	408,037,900.00	418,782,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,003,059,902.06	2,355,412,143.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,003,059,902.06	2,355,412,143.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,933,722,864.65	2,245,747,458.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,127,252,201.00	1,399,813,772.00
210101	Үндсэн цалин	851,173,793.00	1,076,001,183.00
210102	Нэмэгдэл	184,807,838.00	153,375,356.00
210104	Урамшуулал	91,270,570.00	170,437,233.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	141,580,628.35	177,622,628.79
210201	Тэтгэврийн даатгал	97,180,557.35	122,653,680.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,416,478.00	13,870,063.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,974,464.00	11,038,932.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,182,648.00	2,549,114.79
210205	Эрүүл мэндийн даатгал	21,826,481.00	27,510,839.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	401,537,900.00	407,529,017.50
210301	Гэрэл, цахилгаан	11,561,516.00	9,186,266.00
210302	Түлш, халаалт	334,513,280.00	342,924,719.50
210303	Цэвэр, бохир ус	55,463,104.00	55,418,032.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,624,035.80	70,944,874.80
210401	Бичиг хэрэг	9,485,560.00	4,287,930.00
210402	Тээвэр, шатахуун	3,143,000.00	2,199,500.92
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,641,471.80	4,783,400.00
210404	Ном, хэвлэл	00.00	454,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	510,000.00	7,415,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,103,104.00	2,835,410.00
210408	Бараа материал акталсны зардал	2,740,900.00	48,968,233.88
2105	Нормативт зардал	695,650.00	2,440,450.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	695,650.00	2,155,750.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	284,700.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,825,637.00	7,202,450.00
210604	Урсгал засвар	20,825,637.00	7,202,450.00
2107	Томилолт, зочны зардал	4,650,000.00	1,758,000.00
210702	Дотоод албан томилолт	4,650,000.00	1,758,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,098,250.00	2,686,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,498,250.00	2,086,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	174,458,562.50	175,749,465.75
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,910,000.00	4,463,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,229,000.00	3,464,420.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	169,319,562.50	167,821,145.75
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,337,037.41	109,664,684.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	69,329,809.00	77,128,094.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	52,994,400.00	28,908,015.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	15,136,869.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,569,600.00	28,438,410.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,765,809.00	4,644,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	1,253,782.50
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,253,782.50
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,228.41	31,282,808.29
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,228.41	31,282,808.29
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>172,444,997.94</u>	<u>96,922,566.87</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>172,444,997.94</u>	<u>96,922,566.87</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,063,207,767.00</u>	<u>2,266,234,179.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>2,063,207,767.00</u>	<u>2,266,234,179.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,574,259,300.00	1,798,187,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,574,259,300.00	1,798,187,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	80,910,567.00	49,264,279.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,683,187.00	43,575,279.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	61,227,380.00	5,689,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	408,037,900.00	418,782,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	408,037,900.00	418,782,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,063,207,767.00</u>	<u>2,201,903,696.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>2,063,207,767.00</u>	<u>2,201,903,696.00</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>1,993,559,938.59</u>	<u>2,092,239,011.21</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,126,231,599.79	1,399,208,627.00

Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210101	Үндсэн цалин	888,316,899.79	1,075,395,738.00
210102	Нэмэгдэл	100,146,700.00	153,375,656.00
210104	Урамшуулал	137,768,000.00	170,437,233.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	147,377,000.00	177,622,628.79
210201	Тэтгэврийн даатгал	104,240,400.00	122,807,954.79
210202	Тэтгэмжийн даатгал	10,784,100.00	13,969,574.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,627,400.00	10,641,843.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,156,900.00	2,692,418.00
210205	Эрүүл мэндийн даатгал	21,568,200.00	27,510,839.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	401,537,900.00	407,529,017.50
210301	Гэрэл, цахилгаан	11,561,516.00	9,186,266.00
210302	Түлш, халаалт	334,513,280.00	342,924,719.50
210303	Цэвэр, бохир ус	55,463,104.00	55,418,032.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,190,299.80	25,816,680.92
210401	Бичиг хэрэг	4,841,708.00	2,198,700.00
210402	Тээвэр, шатахуун	3,143,000.00	2,199,500.92
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,264,471.80	4,783,400.00
210404	Ном, хэвлэл	5,695,760.00	2,308,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	7,415,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,945,360.00	6,910,780.00
2105	Нормативт зардал	5,843,390.00	18,580,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,563,800.00	5,872,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,279,590.00	12,708,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	170,409,500.00	33,409,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,500,000.00	360,000.00
210602	Тавилга	25,209,500.00	00.00
210604	Урсгал засвар	138,700,000.00	33,049,300.00
2107	Томилолт, зочны зардал	4,650,000.00	1,758,000.00
210702	Дотоод албан томилолт	4,650,000.00	1,758,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	76,116,349.00	6,136,917.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	75,516,349.00	5,536,917.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,203,900.00	22,177,240.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,000,000.00	11,841,940.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,203,900.00	10,335,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,647,828.41	109,664,684.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	69,640,600.00	77,128,094.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	52,994,400.00	28,908,015.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	15,136,869.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,569,600.00	28,438,410.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,076,600.00	4,644,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	1,253,782.50
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,253,782.50

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,228.41	31,282,808.29
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,228.41	31,282,808.29
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	64,330,483.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	64,330,483.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	64,330,483.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	64,330,483.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	64,330,483.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-64,330,483.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,468,610,681.55	2,034,769,644.05	703,095,447.94	4,206,475,773.54
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,468,610,681.55	2,034,769,644.05	703,095,447.94	4,206,475,773.54
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,468,610,681.55	2,034,769,644.05	703,095,447.94	4,206,475,773.54
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	96,922,566.87	96,922,566.87
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,468,610,681.55	2,034,769,644.05	800,018,014.81	4,303,398,340.41

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			0.00	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,216,969,900.00	2,184,433,309.21	32,536,590.79	98.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,216,969,900.00	2,184,433,309.21	32,536,590.79	98.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,173,382,000.00	2,150,880,494.21	22,501,505.79	98.96

Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,417,748,800.00	1,399,208,627.00	18,540,173.00	-	98.69
210101	Үндсэн цалин	1,092,501,000.00	1,075,395,738.00	17,105,262.00	-	98.43
210102	Нэмэгдэл	142,718,900.00	153,375,656.00	10,656,756.00		107.47
210104	Урамшуулал	182,528,900.00	170,437,233.00	12,091,667.00	-	93.38
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	180,326,200.00	177,622,628.79	-2,703,571.21		98.50
210201	Тэтгэврийн даатгал	123,616,300.00	122,807,954.79	-808,345.21		99.35
210202	Тэтгэмжийн даатгал	14,177,500.00	13,969,574.00	-207,926.00		98.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,341,900.00	10,641,843.00	-700,057.00		93.83
210204	Ажилгүйдлийн даатгал	2,835,500.00	2,692,418.00	-143,082.00		94.95
210205	Эрүүл мэндийн даатгал	28,355,000.00	27,510,839.00	-844,161.00		97.02
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	408,782,800.00	407,529,017.50	-1,253,782.50		99.69
210301	Гэрэл, цахилгаан	10,416,500.00	9,186,266.00	-1,230,234.00		88.19
210302	Түлш, халаалт	342,936,300.00	342,924,719.50	-11,580.50		100.00
210303	Цэвэр, бохир ус	55,430,000.00	55,418,032.00	-11,968.00		99.98
2104	Хангамж, бараа материалын зардал	29,367,000.00	29,366,280.92	-719.08		100.00
210401	Бичиг хэрэг	2,198,700.00	2,198,700.00	0.00		100.00
210402	Тээвэр, шатахуун	2,200,000.00	2,199,500.92	-499.08		99.98
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,783,400.00	4,783,400.00	0.00		100.00
210404	Ном, хэвлэл	5,078,100.00	5,078,100.00	0.00		100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,415,800.00	7,415,800.00	0.00		100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,691,000.00	7,690,780.00	-220.00		100.00
2105	Нормативт зардал	18,580,600.00	18,580,600.00	0.00		100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,872,300.00	5,872,300.00	0.00		100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,708,300.00	12,708,300.00	0.00		100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	79,049,300.00	79,049,300.00	0.00		100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,000,000.00	7,000,000.00	0.00		100.00
210602	Тавилга	39,000,000.00	39,000,000.00	0.00		100.00
210604	Урсгал засвар	33,049,300.00	33,049,300.00	0.00		100.00

Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2107	Томилолт, зочны зардал	1,761,200.00	1,758,000.00	-3,200.00	99.82
210702	Дотоод албан томилолт	1,761,200.00	1,758,000.00	-3,200.00	99.82
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,200,800.00	2,200,800.00	0.00	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,600,800.00	1,600,800.00	0.00	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35565300.00	35565240.00	-60.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,700,000.00	12,699,940.00	-60.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,865,300.00	22,865,300.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43587900.00	33552815.00	10,035,085.00	76.98
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,587,900.00	33,552,815.00	10,035,085.00	76.98
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	38,943,100.00	28,908,015.00	10,035,085.00	74.23
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,644,800.00	4,644,800.00	0.00	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,216,969,900.00	2,184,433,309.21	32,536,590.79	98.53
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,798,187,100.00	1,766,904,291.71	31,282,808.29	98.26
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,798,187,100.00	1,766,904,291.71	31,282,808.29	98.26
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	418,782,800.00	417,529,017.50	-1,253,782.50	99.70
132001	Орон нутгийн төсвөөс	418,782,800.00	417,529,017.50	-1,253,782.50	99.70
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01	01	00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	113	113	00	100.00
620001	Удирдах ажилтан	01	01	00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	88	88	00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	25	25	00	100.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	1,223	1,238	15	101.23
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН	1,223	1,238	15	101.23

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

	СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД				
630001	Төрийн өмчит ЕБС	1,223	1,238	15	101.23
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	114	114	00	100.00
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	81	81	00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	33	33	00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		49,264,279.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		49,264,279.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		5,689,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		5,689,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		5,689,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		43,575,279.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		43,575,279.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		15,136,869.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		28,438,410.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		49,264,279.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		49,264,279.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		43,575,279.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		5,689,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын

дүгнэлтийг Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн захирал Л.Ононхүү танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дугаар сарын 29-өөс 2021 оны 02 дугаар сарын 02-ны хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Цэрэнчимэд хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор сумын Эрдэнэмандал сургууль нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 204 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Багш бүр ажлын байрандаа тасралтгүй хөгжиж хэрэгцээт хөтөлбөр боловсруулан суралцагчдын сурлагын амжилт чанар, сурах арга барилд ахиц гарган, сурах хөгжих таатай орчин бүрдүүлнэ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль

3.3 Нягтлан БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2020 онд харьяа орон нутаг дахь Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны 3 дугаар улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардал 1548326.8 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 30966.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2355412.1 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 47108.2 мянган төгрөгөөр тооцов.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 4303398.3 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 96922.6 мянган төгрөгөөр буюу 2.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, Засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	223,531.7	266,162.3	42,630.6
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	6,927.8	6,301.6	(626.2)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	216,603.9	259,860.7	43,256.8
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,982,944.0	4,037,236.0	54,292.0
Үндсэн хөрөнгө	4,421,146.4	4,638,759.6	217,613.1
Хуримтлагдсан элэгдэл	(438,202.4)	(601,523.5)	(163,321.1)
Нийт хөрөнгө	4,206,475.8	4,303,398.3	96,922.6
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,206,475.8	4,303,398.3	96,922.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,206,475.8	4,303,398.3	96,922.6

Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Өмнөх онд 6927.8 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байсан ба харин тайлант онд 6301.6 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байгаа нь өмнөх оноос 626.2 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь өмнөх онд үүссэн өндөр насны тэтгэвэрт гарсан 4 иргэнд олгосон 6301,6 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүйтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 259860.7 мянган төгрөг болж 43256.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тусгай зориулалтын материал 38954.6 мянга, эм боох материал 4363.6 мянга, барилгын засварын материал 17599.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, бичиг хэрэг 5480,5 мянга, аж ахуйн материал 14,5 мянга, бусад хангамжийн материал 12039,3 мянган төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4638759.6 мянган төгрөг болж 217613.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 64330.4 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, үнэ

төлбөргүй хүлээн авсан 157782.7 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансанд 2020 онд төсвийн хөрөнгөөр өнгөт хэвлэгч, өсгөгч, хөгжим зэрэг 10 нэр төрлийн 27828.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, бөхийн дэвжээ, одон бөмбөгийн ширээ зэрэг 6 нэрийн 31980,0 мянга, 50 нэрийн 4522.5 мянган төгрөгийн ном худалдан авсан, бараа материалын данснаас 2 нэрийн 11550,0 мянган төгрөгийн тавилгыг үндсэн хөрөнгөнд шилжүүлж бүртгэсэн, улсын төсвийн хөрөнгө оруулалт, Дэлхийн зөн байгууллагын хөрөнгөөр 12 нэр төрлийн 311770,0 мянган төгрөгийн хөрөнгийг орлогоор бүртгэж, үндсэн хөрөнгө нийт дүнгээрээ 107657,5 мянган төгрөгөөр нэмэгдсэн, барилгын зураг төсөв гэсэн 4500,0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1426628.3 мянган төгрөг болж 319131.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 319131.5 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 4303398.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 96922.6 мянган төгрөгөөр буюу 2.3 хувиар өссөн байна.

Нийт орлого өмнөх оноос 276829.8 мянган төгрөгөөр өссөн байна. Үүнд үнэ төлбөргүй авсан орлого 72864.8 мянга, тусгай зориулалтын шилжүүлэг 223927.8 мянга, орон нутгийн санхүүжилтийн орлого 10744.9 мянган төгрөгөөр тус тус өссөн нь голлох нөлөө үзүүлжээ. Харин туслах үйл ажиллагааны орлого 200,0 мянга, нэмэлт санхүүжилтийн орлого 30507.7 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Нийт зардал 2355412.1 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 352352.2 мянган төгрөгөөр буюу 17.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ-ийн зардал 308603.6 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 5991.1 мянга, хангамж бараа материалын зардал 46320.8 мянга, нормативын зардал 1744.8 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 1990.9 мянга, бусад урсгал зардал 7798.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, эд хогшил, урсгал засварын зардал 13623,2 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 35411.4 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2359138.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2359138.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 142168.3 мянган төгрөгөөр бууруулж 2216969.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр анх 2359138.6 мянган төгрөгийн төсөв батлагдаж 3 удаа тодотгол хийн 2216969.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 1798187.1 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээр, 418782.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн санхүүжилтээр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 418782.8 мянга, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс 1798187.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 2184433.3 мянган төгрөгийг зарцуулж 32536.6 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2184433.3 мянган төгрөг буюу 98.5 хувьтай байгаа нь цалин, НДШ-ийн зардлыг 21243.7 мянга, байр ашиглалттай холбоотой тогтол зардлыг 1253.7 мянга, хангамж бараа материалын зардлыг 719.1 мянга, албан томилолтын зардлыг 3200.0 мянга, бусад урсгал шилжүүлгийн зардлыг 10035.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 71802 хөтөлбөрийн 80109 арга хэмжээ 1253.8 мянга, 81801 арга хэмжээ 10035.1 мянга, 8134 арга хэмжээ 21247.2 мянга, 81835 арга хэмжээ 0.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ	Хувь
НИЙТ ДҮН	2,216,969.9	2,184,433.3	(32,536.6)	98.5
ХӨТӨЛБӨР 71806	19,224.6	19,224.6	-	100.0
АРГА ХЭМЖЭЭ 80101 Үндсэн үйл ажиллагаа	19,224.6	19,224.6	-	100.0
ХӨТӨЛБӨР 71802	2,197,745.3	2,165,208.7	(32,536.6)	98.5
АРГА ХЭМЖЭЭ 80109 ТЗШ-ын байгууллагын тогтмол зардал	418,782.8	417,529.0	(1,253.8)	99.7
АРГА ХЭМЖЭЭ 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	4,644.8	4,644.8	-	100.0
АРГА ХЭМЖЭЭ 81801 Үдийн цай	38,943.1	28,908.0	(10,035.1)	74.2
АРГА ХЭМЖЭЭ 81834 Боловсролын стандарт сургуулыг хэийн явуулах	1,362,742.4	1,341,495.2	(21,247.2)	98.4
АРГА ХЭМЖЭЭ 81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	372,632.2	372,631.7	(0.5)	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,216,969.9	2,184,433.3	(32,536.6)	98.5
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,798,187.1	1,766,904.3	(31,282.8)	98.3
Орон нутгийн төсвөөс	418,782.8	417,529.0	(1,253.8)	99.7

Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үзүүлэлт	Орлогын дүн	зарлагын дүн	5 жилийн тэтгэмж	тэтгэвэрт гарсны тэтгэмж	гүнзгийрүүлсэн сургалтын илүү цаг	гүнзгийрүүлсэн сургалтын ном	халдаг хөшиг	сургалтын төлбөр
5 жилийн тэтгэмж	28,438.4	28,438.4	28,438.4					
тэтгэвэрт гарсны тэтгэмж	15,136.8	15,136.8		15,136.8				
төрийн санхүүжилт		-						
гүнзгийрүүлсэн сургалт	3,679.0	3,679.0			179.0	3,500.0		
заалны түрээсийн орлого	1,350.0	1,350.0					1,350.0	
сургалтын төлбөр	660.0	660.0						660.0
ДҮН	49,264.2	49,264.2	28,438.4	15,136.8	179.0	3,500.0	1,350.0	660.0

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс Шилэн дансны мэдээллийн Төсөв, гүйцэтгэл талбарт сар бүр оруулах 1, тухай бүр оруулах 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт, Бусад талбарт байршуулах мэдээллийг бүрэн байршуулсан байна.

д.д	Хугацаа	төрөл	удаа	хугацаан даа оруулсан	хоцорсон	байршуу лаагүй	хугацаа болоогүй
1	Бүтэн жилээр	11	11	9	0	0	2
2	хагас жилээр	4	4	4	0	0	0
3	улирал бүр	1	4	4	0	0	0
4	сар бүр	3	36	35	1	0	0
5	тухай бүр	8	96	94	2	0	0
6	ДҮН	27	151	146	3	0	2

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар биет бус хөрөнгөнд бүртгэлтэй 4500,0 мянган төгрөгийн Барилгын засварын зураг төсвийг данснаас хасуулах, өндөр насны тэтгэвэрт гарсан 4 иргэнд олгосон 6301,6 мянган төгрөгийг авлагын тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллан мөнгийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 100030000947 дансанд төвлөрүүлэх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй. НДХ, ҮЭХ-оос авах 200,0 мянга, бусад авлага 626.2 мянган төгрөгийг төлүүлэх төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулсан байна. Эрдэнэмандал сургуулийн захирал Л.Ононхүү 2020.12.08-ны өдөр "Тэтгэвэрт гарсан 4 багшийн холбоотой 6301,6 мянган төгрөгийн тэтгэмжийн асуудал Авлигатай тэмцэх газарт шалгагдан одоо хүртэл хариу ирээгүй байна" гэсэн 235 тоот албан бичиг ирүүлсэн байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар санхүүгийн тайланд алдаа, зөрчил илрээгүй, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн, өндөр насны тэтгэвэрт гарсан 4 иргэнд олгосон 6301,6 мянган төгрөгийг авлагын тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, барагдуулах гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тайлант онд Баянхонгор аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020. 08.08-ны 131/ШШ2020/00973 дугаар шийдвэрээр иргэн Л.Ононхүүд олгосон нөхөн олговор 17858742 төгрөгийг буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар төлүүлээгүй, төсөвт хохирол учруулсан тул албан шаардлага, дансны мэдээлэлд Төсөв, гүйцэтгэл талбарт сар бүр оруулах 1, тухай бүр оруулах 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан тул 1 зөвлөмж өгөв. /Хавсралт 1./

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар санхүүгийн тайланд алдаа, зөрчил илрээгүй, шилэн дансны мэдээлэл байршуулахтай холбоотой 1 зөвлөмж өглөө.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн шилэн дансны мэдээлэлтэй холбоотой зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал

2.1.Илрүүлэлт: Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс Шилэн дансны мэдээллийн Төсөв, гүйцэтгэл талбарт сар бүр оруулах 1, тухай бүр оруулах 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн.

2.2.Эрсдэл: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй байх.

2.3.Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсний дагуу төсөв, өмч хөрөнгө зарцуулах шийдвэр, батлагдсан төсөв, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээ, тендерийн ерөнхий мэдээлэл, хагас жилийн санхүүгийн тайланг хугацаанд нь мэдээлж хуулийг хэрэгжүүлж ажиллах.

2.4.Байгууллагаас өгсөн харуу тайлбар:Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:

АУДИТОР

Анхан шатанд хянасан:

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР

Хоёр дахь шатанд хянасан:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.ЦЭРЭНЧИМЭД 2021.02.25

А.ЦЭЭНЯМ 2021.02.25

Б.МӨНХБАТ 2021.02.25



5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо	Аудитын нэр:	Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:		
2020			БНА-2021/57/СТА-ТШЗ		
Шалгагдсан байгууллагын нэр:		Баянхонгор сумын Эрдэнэмандал сургууль	Мянган төгрөг		
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс Шилэн дансны мэдээллийн Төсөв, гүйцэтгэл талбарт сар бүр оруулах 1, тухай бүр оруулах 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	0	зөвлөмж	Захирал, нягтлан бодогч	Л.Ононхүү, Ж.Янжмаа
2	Тайлант онд Баянхонгор аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020. 08.08-ны 131/ШШ2020/00973 дугаар шийдвэрээр иргэн Л.Ононхүүд олгосон нөхөн олговор 17858742 төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлээгүй, төсөвт хохирол учруулсан байна.	17858.7	Албан шаардлага	Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт аудитын албаны дарга	Б.Даваажаргал
3	Өмнөх онд Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн, өндөр насны тэтгэвэрт гарсан 4 иргэнд олгосон 6301,6 мянган төгрөгийг авлагын тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, барагдуулах гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй	6301.0	Албан шаардлага	Захирал, нягтлан бодогч	Л.Ононхүү, Ж.Янжмаа
ДҮН		17858.7			

_____оОо_____